

ЦАХИМ ОРЧИНД ХУВЬ ХҮНИЙ ЭРХИЙГ ХАМГААЛАХ НЬ

PROTECTING HUMAN RIGHTS IN CYBER ENVIRONMENT



МОНГОЛЫН
Дотоод
Хэрэг
Яамдын
Урьдчилсан
Томьёо

Баттөмөрийн Мөнхзул*, Дашдаваагийн Энхболд, Дашцэрэнгийн Эрдэнэбат
Дотоод хэргийн их сургуулийн магистрант

Munkhzul Battumur, Enkhbold Dashdavaa, Erdenebat Dashtseren, MA Scholar,
University of Internal Affairs

*хариуцлагатай зохиогч: munkhzulbattumur11@gmail.com

Хураангуй: Даяаршлын хүчин зүйлийн нөлөөгөөр цахим орчинд суурилсан уламжлалт бус хэрэглээ тэргүүлж, иргэд бүхий л төрлийн мэдээллийг цаг хугацаа, орон зайнаас үл хамааран түргэн шуурхай эрж хайж, хүлээн авч, түгээх боломжтой болсон. Иймд цахим орчинд хүний эрх, эрх чөлөөг хамгаалах зорилгоор эрх зүйн зохицуулалт хийх, тодорхой хязгаарлалт тогтоох үйл явц өрнөх болсон нь цахим орчинд хувь хүний эрхийг хамгаалах нь нийгмийн тулгамдсан асуудлын нэг болсныг харуулж байна. Хүн болж төрснөөрөө баталгаатай эдлэх эрхийн нэг бол халдашгүй, чөлөөтэй байх эрх тэр дундаа нэр төр, алдар хүндээ хамгаалуулах явдал юм. Ардчилсан нийгмийн үнэт зүйл болох үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх, үг хэлэх эрхийг хүн бүхэн эдлэх ёстой. Эдгээр эрхүүд нь бие биетэйгээ харилцан уялдаатай, бие биеэсээ хамаарсан, салшгүй холбоотой байдаг. Дээрх хүний эрхийг хамгаалах хууль, эрх зүйн орчин цахим орчинд хүний эрх, эрх чөлөөний хэрэгжилтийг хэрхэн хангаж байгааг судлах зорилгоор энэхүү сэдвийг сонгосон. Уг судалгааны ажлыг шинжлэх ухааны харьцуулах болон баримт, бичиг судлалын судалгааны аргуудыг түлхүү ашиглаж, илүү өргөн хүрээнд, цогц байдлаар хийсэн. Уг судалгааны ажил нь цахим орчин дахь хувь хүний нэр төр, алдар хүндэд халдаж буй зөрчлийг тодорхойлж, цахим орчинд уг эрхийг хамгаалахаар хийгдэж урьдчилан сэргийлэх болон таслан зогсоохтой холбоотой мэдээлэлд хяналт тавих оновчтой тогтолцоог хэрэгжүүлэх арга замыг тодорхойлоход туслалцаа үзүүлэх ач холбогдолтой.

Abstract: Due to the influence of globalization, unconventional consumption based on the Internet have taken the lead, and citizens have been able to search, receive, and distribute all kinds of information quickly regardless of spatiotemporality. Therefore, legal regulations should be made to protect human rights and freedoms, and the process of setting certain limits is underway in order to protect individual rights in the online environment. One of the rights guaranteed by birth as a human being is the right to be inviolable and free, including the protection of one's honor and reputation. Everyone should enjoy the right to free expression of opinions and speech, which are values of a democratic society. These rights are interconnected, interdependent, and inextricably linked.

The paper is aimed at studying how law and legal framework for protecting human rights ensures the implementation of human rights and freedoms in the Internet environment. The research work was carried out in a broader and more comprehensive manner, using mainly scientific comparative and documentary research methods. This research work is important in identifying violations of personal honor, reputation, and business reputation in the online environment and in identifying ways to implement an

effective system for monitoring information related to the prevention and suppression of violations carried out to protect these rights in the online environment.

Түлхүүр үгс: Олон нийтийн цахим сүлжээ, интернэт, хүний эрх, хүний нэр төр, алдар хүнд.

Keywords: Social networks, Internet, human rights, human dignity and reputation.



အထူးသတိပြုရန်

Үндэслэл

Цахим орчин ашиглан орон зай, цаг хугацаанаас үл хамааран дэлхийн өнцөг булан бүрээс мэдээ, мэдээллийг эрж хайх, хүлээн авах, түгээх, харилцан бие биетэйгээ холбоо тогтоох боломж бий болж олон нийтийн цахим сүлжээ хэрэглэгчдийн тоо өдрөөс өдөрт өсөж байгаагийн хэрээр уг харилцааг тодорхойлох, боловсронгуй болгох шаардлага зүй ёсоор бий болж байна.

Үүний тод жишээ нь цахим орчинд “хүний нэр төр, алдар хүндэд халдах”, “гүтгэх”, “худал мэдээлэл гараах”, “хувийн нууцад халдах”, “хүний эмзэг мэдээллийг задруулах” “заналхийлэх” зэрэг хэлбэрээр илэрч байна.

Иймд дээрх хүний халдашгүй, чөлөөтэй байх эрхийн зөрчлүүдээс урьдчилан сэргийлэх, үүсэн бий болох үр дагаврыг бууруулах талаарх эрх зүйн зохицуулалтыг тодорхой болгож, Монгол Улсад хамгийн өргөн хэрэглэгдэж буй сошиал платформууд болох Твиттер, Фейсбүүк зэрэг компаниудын тогтоосон үйлчилгээний нөхцөл, гомдол хүсэлт шийдвэрлэх дүрэм, журмуудтай уялдуулах шаардлага тулгарч байна.

Мөн иргэд, олон нийт үзэл бодлоо илэрхийлэх, үг хэлэх эрх чөлөөгөө эдлэхдээ бусдын нэр төр, алдар хүнд, ажил хэргийн нэр хүндийг гутаан доромжлох үйлдлүүд түгээмэл гарч байгаа тул олон нийтийн сүлжээнд хүний эрхийг хамгаалах эрх зүйн зохицуулалт шаардлагатай гэж үзэж, түүний зорилго, хамрах хүрээ,

хязгаарыг тогтоох зорилгоор энэхүү судалгааг гүйцэтгэлээ.

Үндсэн хэсэг

Үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрх нь нийгэм дэх өөрийн алдаатай сэтгэлгээг засаж өөрчлөх боломжийг хувь хүнд олгодог жам ёсны эрхүүдийн нэг бөгөөд ардчилсан нийгмийн хамгийн чухал эрх чөлөөний нэгэнд тооцогддог. Өөрөөр хэлбэл үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрх нь хувь хүн нийгэмтэй шууд харьцах харилцааны илэрхийлэл төдийгүй нийтийн ач холбогдол бүхий асуудлыг чөлөөтэй ил тод хэлэлцэж, үнэнийг олж мэдэх, цаашлаад нийгмийн үзэл бодлыг бий болгоход чухал ач холбогдол бүхий эрх чөлөө юм.

Манай Улсын хувьд иргэний үзэл бодлоо илэрхийлэх, үг хэлэх эрх, эрх чөлөөг 1992 оны Монгол Улсын Үндсэн хууль болон Монгол Улсын нэгдэн орсон олон улсын гэрээ, конвенцуудаар баталгаажуулж өгсөн байдаг.

Монгол Улсын Үндсэн хуулийн 16 дугаар зүйлийн 16 дахь хэсэгт “итгэл үнэмшилтэй байх, үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх, үг хэлэх, хэвлэх нийтлэх, тайван жагсаал, цуглаан хийх, эрх чөлөөтэй”, мөн зүйлийн 17 дахь хэсэгт “төр, түүний байгууллагаас хууль ёсоор тусгайлан хамгаалбал зохих нууцад хамаарахгүй асуудлаар мэдээлэл хайх, хүлээн авах эрхтэй (Монгол Улсын Үндсэн хууль, 1992) хэмээн баталгаажуулсан.

Мөн Иргэний болон улс төрийн
эрхийн тухай олон улсын Пактын 19



ᠮᠣᠩᠭᠣᠯ ᠤᠯᠤᠰ ᠤᠨ
ᠤᠨᠳᠦᠰᠡᠨ ᠤᠯᠤᠰ ᠤᠨ
ᠤᠨᠢᠭᠡᠮᠡᠨ ᠤᠨᠤᠯᠤᠰ ᠤᠨ
ᠤᠨᠤᠯᠤᠰ ᠤᠨᠤᠯᠤᠰ ᠤᠨ

дүгээр зүйлийн 2 дахь хэсэгт “хүн бүр санаа бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрхтэй, энэ эрхэнд төрөл бүрийн мэдээлэл болон үзэл санааг улсын хил хязгаарыг үл харгалзан амаар, бичгээр эсхүл хэвлэлийн буюу уран сайхны аргаар эсхүл өөрийн сонгосон бусад аргаар эрх хайх, хүлээн авах, түгээх эрх чөлөө багтана” (Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын Пакт, 1966), Хүний эрхийн Түгээмэл Тунхаглалын 19 дүгээр зүйлд тусгалаа олж “мэдээллийг улсын хил хязгаараар үл хязгаарлан, боломжтой бүхий л арга хэрэгслээр эрж хайх, хүлээж авах, түгээх” (Хүний эрхийн түгээмэл тунхаглал, 1948) хэмээн тунхагласан байдаг.

Хүн бүрийн эрхийн хязгаар нь нийгмийн бусад гишүүдэд эрхээ эдлэх боломжийг баталгаажуулахад орших бөгөөд энэ зааг хязгаарыг гагцхүү хуулиар тодорхойлно. (Тэмүүжин, 2004)

Монгол Улсын Үндсэн хууль болон Олон улсын хүний эрхийн гэрээний дагуу хэзээ ч ямар ч тохиолдолд хязгаарлаж үл болох туйлын (абсолют) эрхүүд бий. Жишээлбэл, эрүү шүүлт, хүнлэг бус, хэрцгий, доромж хандлагаас ангид байх, үзэл бодолтой байх (энэ нь үзэл бодлоо илэрхийлэхээс ялгаатай) эрхийг ямар нэгэн байдлаар хязгаарлаж болохгүй. Зөвхөн Үндсэн хуульд заасан бүх гол нөхцөлийг нэгэн зэрэг хангасан зайлшгүй тохиолдолд туйлын эрхээс бусад үндсэн эрх, эрх чөлөө (үзэл бодлоо илэрхийлэх, жагсаал, цуглаан хийх зэрэг)-г хязгаарлаж болно. (Мөнхсайхан, 2017)

Үндсэн эрхийг ийнхүү хязгаарлахад заавал хангах ёстой гол нөхцөлийг Үндсэн хуульд заасан. Эдгээр гол нөхцөлөөс зургааг нь танилцуулъя: (1) үндсэн эрхийг гагцхүү хуулиар хязгаарлах; (2) хязгаарлалт нь

үндэсний аюулгүй байдал, бусад хүний эрх, эрх чөлөө, эсхүл нийгмийн дэг журам гэсэн ашиг сонирхлыг хангах; (3) хязгаарлалт нь тохирсон (зайлшгүй) байх; (4) үндсэн эрхийг эдлүүлэх; (5) ялгаварлан гадуурхахгүй байх; (6) хараат бус шүүхээр хянагддаг байх.

Дээрх зургаан гол нөхцөл нь үндсэн эрхийг хязгаарлах наад захын гол нөхцөл боловч энэ нь үүнээс өөр нөхцөл тавихыг үгүйсгээгүй. Үндсэн хууль ядаж эдгээр зургаан нөхцөлийг бүгдийг зэрэг хангаснаас бусад тохиолдолд үндсэн эрхийг хязгаарлахыг хориглодог. Туйлын эрхээс бусад үндсэн эрх, эрх чөлөөг хязгаарлахад энэ зургаан гол нөхцөлийг бүгдийг нь бүрэн хангасан байх ёстой.

Үндсэн эрхийн хязгаарлалт зүй ёсных уу, үгүй юу гэдгийг хэмжихэд дээрх зургаан нөхцөлөөс эхний гурвыг хэрэглэх шаардлага олон улсын хүний эрхийн гэрээ дэх зарим эрх дээр илүү тодорхой бичигдэж, хэрэглэгддэг. Жишээлбэл, Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын Пакт (ИБУТЭТОУП)-ын 19-р зүйлд хуулиар тогтоосон доорх үзэл бодлоо илэрхийлэх эрхийн хязгаарлалтыг зөвшөөрдөг. Үүнд:

а/ бусдын эрх, нэр төрийг хүндэтгэх;

б/ үндэсний аюулгүй байдал, нийгмийн дэг журам, хүн амын эрүүл мэнд, ёс суртахууныг хамгаалах гэж заасан байдаг. (Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пакт, 1966).

Аливаа мэдээ, мэдээллийг эрж хайх, хүлээн авах, түгээх, үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрхийн сонгодог хэрэгсэл бол цахим сүлжээ юм. Техник технологийн хөгжилтэй зэрэгцэн бидний өдөр тутмын амьдрал цахим орчин, олон нийтийн сүлжээнд өрнөх болж, уг уламжлалт бус цахим

харилцаанд оролцогчдын хүний эрх, эрх чөлөөний асуудал хөндөгдөж байна. Цахим эрх хэмээх ойлголтыг “хувь хүмүүст цахим хэвлэл мэдээлэлд нэвтрэх, ашиглах, зохиох, хэвлэн нийтлэх, компьютер, бусад электрон хэрэгсэлтэй байх, мэдээлэл харилцааны сүлжээнд нэвтрэх, тэдгээрийг ашиглах, боломж олгож буй хүний эрх юм” (Ди Ар Ай & Глоб интернэшнл төв, 2018) хэмээн тодорхойлсон байдаг.

21-р зууны үсрэнгүй хөгжлийн нэг том дэвшил нь техник, технологи болон интернэтийн хөгжил юм. Энэхүү хөгжлөөс шалтгаалан нийгэм дэх хүмүүсийн харилцааны хэв маяг хувьсан өөрчлөгдөж, мэдээллийн хуучин арга барилаасаа татгалзаж блог болон социал ертөнц хөгжсөнөөр интернэт хэрэглэгчид зөвхөн мэдээлэл авагч биш өөрөө нийтлэгч болж мэдээллийг олны анхааралд оруулж хэлэлцэх боломж нээгдсэн юм.

Интернэт (англ. internetnetwork гэсэн үгнээс бүтсэн нийлмэл үг бөгөөд inter - “хооронд, дунд”; network - “сүлжээний алба” буюу товчоор “сүлжээ”) гэдэг нь стандарт IP протоколыг ашиглан өгөгдлийг дамжуулах боломж бүхий харилцан холбогдсон компьютеруудыг сүлжээ бөгөөд энэхүү сүлжээ нь дэлхий даяар тархсан байдаг. Үндсэндээ интернэтийг “сүлжээнүүдийн сүлжээ” хэмээн нэрлэж болох ба уг сүлжээнд хот хоорондын, академик, бизнес болон засгийн газрын гэх мэт хэдэн сая сүлжээнүүд багтсан байна. Интернэт гэдэг нь дэлхийн ихэнх улс орныг холбосон олон сая компьютерын сүлжээ ба асар их мэдээллийн санг тодорхойлсон нэр юм. (Монгол Улсын засгийн газар et al., 2023)

АНУ-ын судлаач Э.Дэннис, Д.Мэррил нарын тодорхойлсноор “Нийгэм ард иргэдийн өөр хоорондоо компьютерын сүлжээ ашиглан

харилцаж байгаа нь олон нийтийн мэдээллийн хэрэгсэл, сэтгүүл зүйд хамааруулан үзэж болохгүй” гэжээ.

Орчин үед “Олон нийтийн сүлжээ /харилцаа холбоо/” гэсэн ойлголтыг “Олон нийтийн мэдээллийн сүлжээ” гэсэн ойлголттой хольж ойлгосоор байдаг. Фамичев И.Д тодорхойлсноор олон нийтийн мэдээллийн сүлжээг 1.Харилцах, 2. Мэдээлэх гэж ангилж авч үзсэн байдаг бөгөө тэдгээр нь:

- Үнэт зүйлийн чиг баримжаа олгох,
- Нийгмийн зохион байгуулалт,
- Сэтгэл зүйн чиг баримжаа,
- Идэвхтэй оролцоо хангах чиг үүргүүдийг гүйцэтгэдэг хэмээжээ.

Олон нийтийн сүлжээ цахим хуудаснууд нь хэрэглэгчдэд цахим орчинд /интернэт/ мэдээ мэдээллийг бүтээх, солилцох, хэрэглэх боломжийг олгодог. Үүнд манай улсад өргөн хэрэглэгдэж байгаа нь Фейсбүүк, Твиттер, YouTube зэрэг текст, зураг, дүрс бичлэг бүхий мэдээллүүдийг түгээх, санал сэтгэгдэл үлдээх, уг мэдээлэл сэтгэгдлүүдээ цааш нь бусдад тараах өргөн боломж бүхий цаг хугацаа хэмнэдэг, зорилтот зах зээл болон аль болох олон хүнд хүрэх боломж сайтай, үр дүнг хэмжих боломжтой, бараг зардалгүй буюу маш бага зардалтай.

Юуны өмнө Social Media буюу бидний хэрэглэж ойлгож байгаа олон нийтийн мэдээллийн цахим сүлжээ гэдэг утгаар ойлгогдон хэрэглэгдэж байгаа үгийн тайлбар талаас нь сонирхвол:

Social – нийгмийн, олон нийтийн, нийтэч

Media – мэдээллийн гол хэрэгсэл гэсэн англи үг.

“Олон нийтийн мэдээллийн хэрэгсэл” гэсэн энэ үгийг бид өнөөдөр *Олон нийтийн цахим сүлжээ* гэж ойлгож ирсэн.





Монгол хэлний тайлбар тольд “Цахим” гэдэг нь *нэгдүгээрт*, цахилгаан тооцоолон бодох техник, ийм төрлийн техник ашиглан үйл ажиллагаа явуулах, цахим бараа, цахим тооцоолуур, цахим захиа, цахим шуудан, цахим багаж, цахим тоноглол, цахим карт, цахим хуудас (Монгол толь, n.d.) *Хоёрдугаарт*, маш хурдан, цахилгаан цахих мэт хурдтай, цахим хурдыг ойлгоно гэж заасан байдаг. (Монгол толь, n.d.)

“Компьютер болон мэдээллийн технологийн сүлжээ” нь 2 буюу хэд хэдэн компьютер, ухаалаг технологи-хэрэгсэл хоорондоо холбогдон мэдээлэл болон эх сурвалжууд, нэмэлт төхөөрөмжүүдийг хамтран ашиглах боломжоор хангагдахыг хэлнэ. (Болдбаатар et al., 2015) Компьютерын хамгийн том буюу олныг хамарсан өргөн сүлжээ нь интернэт юм.

Facebook, Twitter олон нийтийн сүлжээний хэрэглээ нэмэгдэж, уг олон нийтийн сүлжээнүүдэд ёс бус үйлдлүүд ч ихээр нэмэгдэх хандлагатай байна. Үүний нэг нь хэрэглэгчийн хувийн мэдээллийг ашиглан хуурамч хаяг дуурайлган үүсгэж, тухайн хэрэглэгчийн өмнөөс буруу ташаа мэдээлэл тараах, нэр хүндэд нь халдах явдлууд ихээр нэмэгдэх болсон.

Интернэт нь иргэдийн өдөр тутмын хэрэглээ болж, интернэт хэрэгслийг мэдээллийн эх сурвалж болгон ашиглах, түүнчлэн олон нийтийн сүлжээ ашиглан үзэл бодлоо илэрхийлэх, аливаа зүйлийг нийтлэх болжээ. (Эрдэм-Ундрах et al., 2018)

Монгол Улсад иргэний дүрсийг гэрэл зураг, кино, дүрс бичлэгийн хальс, хөрөг зураг болон бусад хэлбэрээр өөрийнх нь зөвшөөрөлгүйгээр нийтэлсэн, олон нийтэд үзүүлсэн тохиолдолд Иргэний хуульд заасны дагуу эдийн бус гэм хор учруулсан гэж үзэж шаардах эрх үүсдэг

бол Хүний нэр төр, алдар хүнд, хуулийн этгээдийн ажил хэргийн нэр хүндэд халдсан илт худал мэдээллийг олон нийтэд тараасан бол эрүүгийн хариуцлага хүлээлгэх хуулийн зохицуулалттай.

Монгол Улсын Их хурлаас 2020 оны 01 дүгээр сарын 20-ны өдөр Эрүүгийн хуульд нэмэлт оруулж “Худал мэдээлэл тараах” гэмт хэргийг шинээр хуульчлан Эрүүгийн хуулийн Тусгай ангийн 13.14 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт “Хүний нэр төр, алдар хүнд, хуулийн этгээдийн ажил хэргийн нэр хүндэд халдсан илт худал мэдээллийг олон нийтэд тараасан бол дөрвөн зуун тавин мянган төгрөгөөс нэг сая гурван зуун мянган төгрөгөөр торгох, эсхүл арваас гучин хоног хүртэл хугацаагаар нийтэд тустай ажил хийлгэх, эсхүл нэг сараас гурван сар хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах ял шийтгэнэ” гэж оруулж өгсөн бөгөөд энэхүү нэмэлт нь 2020 оны 02 дугаар сарын 13-ны өдөр “Төрийн мэдээлэл” эмхэтгэлд нийтлэгдсэн.

Монгол Улсад сошиал медиа хэрэглэгчдийн тоо ялангуяа Фейсбүүк хэрэглэгчдийн тоо сүүлийн жилүүдэд нэн эрчимтэй өсөж байна. Энэ нь хүн амын мэдээлэл хүлээн авах аргыг өөрчлөөд зогсохгүй бизнес эрхлэгчдийн зах зээлд мэдээлэл хүргэх арга барилд ч мөн адил томоохон өөрчлөлт авч ирж байгаа билээ. Олон улсын судалгааны байгууллагаас Монгол Улсад 2024 оны байдлаар нийт хүн ам 3.4 сая байна. Үүний 83.9 хувь буюу 2.91 сая хүн интернэт ашигладаг бөгөөд нийт 2.5 сая хүн фейсбүүк ашиглаж байна гэх тоон судалгаа гаргасан байна. (Nathouse Marketing, 2024) Ийнхүү цахим хэрэглэгчийн тоо өсөх тусам цахим орчин дахь гэмт хэргийн төрөл болон түүний тоо, хэмжээ нэмэгдсээр байна. (Түмэндэмбэрэл et al., 2022)

Даяаршлын хүчин зүйлийн нөлөөгөөр нийгмийн аюулгүй байдалд цахим орчинд хувь хүний халдашгүй, чөлөөтэй байх эрхэд үзүүлж буй сөрөг нөлөө өдрөөс өдөрт улам бүр нэмэгдэж түүнийг бууруулах арга замыг тодорхойлох, хэрэгцээ, шаардлагыг бий болж байна. Тэр дундаа цахим орчныг ашиглан хувь хүний нэр төр, алдар хүнд, ажил хэргийн нэр хүндэд халдах үзэгдэл нэлээдгүй нэмэгдэх болсон.


Үүнтэй холбоотойгоор цахим орчинд хүний эрхийг хамгаалах чиглэлээр Монгол Улсын Засгийн газар нь Монгол Улсын Их Хурлын 2020 оны 24 дүгээр тогтоолоор баталсан Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрт “Хүний эрхийг дээдэлсэн, цахим засаглалыг дэмжсэн, технологийн аюулгүй, зохистой харилцааг зохицуулсан хууль, эрх зүйн орчныг бүрдүүлж, төр, хувийн хэвшлийн түншлэлийг шинэ түвшинд гаргана”, мөн Монгол Улсын Их Хурлын 2021 оны 12 дугаар тогтоолоор батлагдсан Монгол Улсын хууль тогтоомжийг 2024 он хүртэл боловсронгуй болгох үндсэн чиглэлд “Цахим орчинд хүний эрхийг хамгаалах хууль эрх зүйн орчныг бүрдүүлэх” зэрэг бодлогыг үндэслэн 6 бүлэг, 12 зүйлтэй “Олон нийтийн сүлжээнд хувь хүний эрхийг хамгаалах тухай” хуулийг санаачилж, 2023 оны 01 дүгээр сарын 20-ны батлагдсан хэдий ч тус хуулийг хүчин төгөлдөр үйлчилж

эхлэхээс өмнө Монгол Улсын Ерөнхийлөгч 2023 оны 01 дүгээр сарын 30-ны өдрийн Е/03 дугаартай “Хуульд хориг тавих тухай” албан бичгийг Монгол Улсын Их Хуралд хүргүүлж, Монгол Улсын Их хурал хоригийг хүлээн авснаар тус хуульд хориг тавьсан.

Цагдаагийн байгууллага 2020-2024 онд иргэн, хуулийн этгээдээс худал мэдээлэл тараах гэмт хэрэгтэй холбоотой 2980 гомдол хүлээн авснаас 2077 буюу 69 хувь нь нийслэлд, 903 буюу 31 хувь нь орон нутагт бүртгэгдсэн байна.

Дээрх бүртгэгдсэн гомдол, мэдээллүүдэд мөрдөн шалгах ажиллагаа явуулсны үндсэн дээр нийт гомдлын 436 буюу 14 хувийг хэрэг бүртгэлтийн хэрэг нээн шалгаж 109 хэргийг шүүх рүү шилжүүлсэн байх бөгөөд Монгол улсын хэмжээнд 2020-2024 оны хооронд нийт 109 худал мэдээлэл тараах гэмт хэрэг шүүхээр эцэслэн шийдвэрлэгдсэн байгаагаас 50 буюу 45 хувь нь нийслэлд, 59 буюу 55 хувь орон нутагт шийдвэрлэгдсэн байна.

Шүүхээр шийдвэрлэгдсэн 109 худал мэдээлэл тараах гэмт хэргийн 11 буюу 10 хувь нь 2020 онд, 19 буюу 17 хувь нь 2021 онд, 14 буюу 13 хувь нь 2022 онд шүүхээр шийдвэрлэгдэж байсан бол тухайн төрлийн гэмт хэргийн шүүхээр шийдвэрлэгдэх байдал 2023, 2024 онд огцом өссөн байна.



Зураг 1. Худал мэдээлэл тараах гэмт хэргийн тархац




МОНГОЛ УЛСЫН
ХҮҮЛЬД ХОРИГ ТАВИХ
ТУХАЙ



Хууль сахиулахуй

Дээрх хэргүүдийн шийдвэрлэлтийг авч үзвэл хялбаршуулсан журмаар шийдвэрлэсэн хэрэг 45, ердийн журмаар шийдвэрлэсэн хэрэг 59, гэмт хэргийн

шинжгүй үндэслэлээр хэрэгсэхгүй болгосон хэрэг 2, Өршөөлийн тухай хуулийн 5.1 дүгээр зүйлд зааснаар өршөөсөн хэрэг 2, тэнссэн 1 хэрэг тус тус эзэлж байна.



Зураг 2. Худал мэдээлэл тараах гэмт хэргийн шийдвэрлэлт


Хялбаршуулсан болон ердийн журмаар шийдвэрлэгдсэн 104 хэргийн 83 буюу 79 хувийг торгох ял, 13 буюу 12.5 хувийг зорчих эрхийг хязгаарлах ял, 8 буюу 8.5 хувийг нийтэд тустай ажил хийлгэх ялаар тус тус шийтгэсэн байна

Шүүхээр шийдвэрлэгдсэн 109 хэргийн 73 буюу 66 хувийг хувь хүний нэр төрд халдсан хэрэг, 34 буюу 31 хувийг хувь хүний ажил хэргийн нэр хүндэд халдсан хэрэг, 2 буюу 3 хувийг

хуулийн этгээдийн нэр хүндэд халдсан хэрэг тус тус эзэлж байна.




Зураг 3. Ял шийтгэлийн төрөл



Зураг 4. Худал мэдээлэл тараах гэмт хэрэгт өртсөн объект

Монгол улсын хэмжээнд сүүлийн 5 жилийн байдлаар шүүхээр шийдвэрлэгдсэн худал мэдээлэл тараах 109 гэмт хэргийн 106 буюу 97 хувь нь

фейсбүүк орчинд, 3 буюу 3 хувь нь Х буюу Твиттер орчинд үйлдэгдсэн байна.



Зураг 5. Худал мэдээлэл тараах гэмт хэрэг үйлдэгдсэн орчин

Дүгнэлт

Монгол Улсад цахим сүлжээний хэрэглээ эрчимтэй нэмэгдэж, үүнтэй хамт цахим орчин дахь хүний эрхийн зөрчил нэмэгдэж байна. Олон нийтийн цахим сүлжээ, тэр дундаа фейсбүүк, твиттер зэрэг платформууд нь мэдээлэл харилцааны чухал суваг болж, иргэдийн дунд санаа бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрх чөлөөг хангах зорилготой боловч энэ нь гүтгэлэг, худал мэдээлэл тараах, хувийн нууц задруулах зэрэг хүний эрхийн зөрчилд хүрэх эрсдэлтэй байна.

Хүний халдашгүй, чөлөөтэй байх тэр дундаа нэр төр, алдар хүнд, ажил хэргийн нэр хүндээ хамгаалуулах болон үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх үндсэн 2 эрх нь зарим тохиолдолд нэг нь нөгөөгөөсөө болж зөрчигдөхөд хүрдэг. Өөрөөр хэлбэл үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрх нь халдашгүй, чөлөөтэй байх эрхтэй харилцан уялдаатай бөгөөд нэг нь нөгөөгөө хязгаарлах байдлаар оршдог. Жишээ нь, хүн өөрийн үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх үед, тэр нь бусдыг доромжлох, гүтгэх худал

мэдээлэл тараах эсвэл бусдын эрхийг зөрчихгүй байх ёстой.

Хүний үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрх нь бусдын халдашгүй чөлөөтэй байх эрхийг хүндэтгэн, тэдний эрхийг доромжлохгүйгээр хэрэгжих ёстой.

Товчхондоо хүний үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрх нь хүний халдашгүй чөлөөтэй байх эрхтэй харилцан уялдаа холбоотой бөгөөд эдгээр эрхүүд хоорондоо тэнцвэртэй, нэгнийгээ хүндэтгэн хэрэгжих ёстой. Тухайлбал, хүний үзэл бодлоо илэрхийлэх эрх нь бусдын халдашгүй байдлыг зөрчихгүй, зохих хязгаарлалтуудтай байж болно.

Тиймээс үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрх ба нэр төрөө хамгаалуулах эрхийн харилцан тэнцвэртэй байдлыг хангасан эрх зүйн зохицуулалтыг бий болгох асуудал хөндөгдсөөр байна.

Хүний нэр төр, алдар хүндийг хүний үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрх чөлөөг хооронд нь жишиж харьцуулах замаар жинлэх боломжгүй хэдий ч эрх зүйн орчин





үеийн чиг хандлагаар үүнийг эрхийн зөрчилдөөн бус үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрх чөлөө болон нэр төр, алдар хүнд, ажил хэргийн нэр хүнд зэрэг "нийтийн эрх ашиг" хоорондын тэнцвэрт байдал гэх хандлагаар авч үзэж байна.

Иймд хоёр эрх хоорондоо аль нэг нь зөрчигдөхөөс нааш хангагдах боломжгүй бус, харин уг асуудлыг тодорхой зарчимд нийцүүлэн хуульчилж, хэрэг маргааныг шийдвэрлэхдээ шүүх үүнийг баримтлах тохиолдолд эрхийн зөрчилдөөнгүйгээр зохицуулагдах боломжтой байна.

Нөгөөтээгүүр энэхүү хоёр үндсэн эрхийн тэнцвэрийг хангахад хууль, эрх зүйн орчныг бүрдүүлэхээс гадна иргэдийн хүний эрхийн мэдрэмж, эрх зүйн боловсрол мөн чухал нөлөөтэй. Иргэд үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэхдээ үнэн зөв мэдээлэлтэй, тухайн асуудалд ул суурьтай хандсан байх ёстой. Таны үзэл бодлыг илэрхийлэх тэрхүү мэдээлэл нь хэн нэгний эрх, эрх чөлөөнд саад учруулахааргүй, гэм хор хүргэхээргүй байх учиртай. Нэг хүний эрх нөгөө хүний эрхээр хязгаарлагддаг гэдгийг умартах ёсгүй. Германы сонгодог философич Г.В. Гегель "Хүн эрх чөлөөтэй байна гэдэг нь хүн өөрийн үйлдлийн хүрээ хязгаар, зайлшгүй шинжийг ухамсарлах явдал" гэж хэлсэн байдаг.

Санал

Нэгдүгээрт. Иргэд, олон нийт үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрхээ эдлэхдээ хүний нэр төр, алдар хүнд, ажил хэргийн нэр хүндэд халдах явдал цөөнгүй байгаа тул урьдчилан сэргийлэх зорилгоор Иргэний хууль болон Эрүүгийн хуульд заасан хариуцлага хүлээлгэх үндэслэлийг тайлбарлан таниулж, мэдээлэх арга хэмжээг зохион байгуулах.

Хоёрдугаарт. Цахим орчинд худал мэдээлэл тараах замаар хүний эрх зөрчих явдал гарсан тохиолдолд цагдаагийн байгууллага нэн даруй шалгаж, худал мэдээлэл болох нь тогтоогдсон тохиолдолд цагдаагийн байгууллага болон мэдээллийн хохирогч болох субъектийн хүсэлтээр мэдээллийг нэн даруй устгах арга хэмжээг холбогдох байгууллагатай хамтран хэрэгжүүлэх.

Гуравдугаарт. Цахим орчинд хүний эрх зөрчих явдлаас урьдчилан сэргийлэх чиглэлээр үүрэн телефоны оператор компаниуд /Мобиком, Скайтел, Юнител, Жимобайл/, түүнчлэн хэвлэл мэдээллийн байгууллагатай нягт хамтран ажиллах.

Ашигласан материал

- Монгол Улсын Үндсэн хууль (Монгол Улсын Их Хурал 1992 оны 1 13).
Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пакт (Нэгдсэн үндэсний байгууллага 1966).
Хүний эрхийн түгээмэл тунхаглал (Нэгдсэн үндэсний байгууллага 1948 оны 12 10).
Тэмүүжин, Х. (2004). *Jus Frast буюу ёст үг*. Улаанбаатар: МУИС, Хууль зүйн сургууль.
Мөнхсайхан, О. (2017). Үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөнд нийцүүлэн гүтгэлгийг зохицуулах нь. *Эрх зүй сэтгүүл*.
Ди Ар Ай, & Глоб интернэшнл төв. (2018). *"Хүний эрхийн тухай мэдээлж, сурвалжлах нь" хэвлэл мэдээллийнхэнд зориулсан гарын авлага*. Улаанбаатар хот.
Монгол Улсын засгийн газар, Европын холбоо, НҮБ-ийн Хүнс, хөдөө аж ахуйн байгууллага, & Олон улсын хөдөлмөрийн байгууллага. (2023). *Цахим үйлчилгээний ажилтан багийн гарын авлага*. Улаанбаатар.